ӨГӨГДЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2026 оны 10 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Өгөгдлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч өгөгдөл нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, инновац, хиймэл оюуны хөгжлийн стратегийн нөөц болж байгааг харгалзан өгөгдлийг үүсгэх, хадгалах, боловсруулах, солилцох, дахин ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, төр, хувийн хэвшилд хуримтлагдсан өгөгдлийн чанар, ангилал, уялдаа холбоо, дахин ашиглалт хангалтгүй, дотоодын дата төв болон үүлэн тооцооллын дэд бүтэц хязгаарлагдмал байгааг үндэслэн өгөгдлийн засаглал, мэдээллийн болон кибер аюулгүй байдал, хувийн мэдээллийн хамгаалалт, дата төвийн үйл ажиллагааны харилцааг цогцоор зохицуулах, төрийн бодлого, үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх, хиймэл оюуны хөгжлийг дэмжих зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хууль санаачлагч хуулийн төсөл батлагдсанаар иргэн, төрийн байгууллагад зардал үүсэхээр шинэ буюу нэмэлт үүрэг ногдуулаагүй байна. Харин өгөгдлийн дэд бүтэц, үүлэн тооцоолуур, өгөгдлийн стандарт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой зардал гарахаар тооцсон байна.

Уг хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа өгөгдлийн өмчлөл, эзэмшил, мэдээлэл зуучлал, дэд бүтэц, өгөгдлийн аюулгүй байдал, нууцлалыг хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат иргэдийн хувийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангах, мэдээлэлд хандах зөвшөөрөл, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, мөн эрүүл мэндийн болон төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулах, өгөгдлийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд хууль батлагдсанаар мэдээллийн технологийн салбарын борлуулалтын орлого, экспортын хэмжээ хэрхэн өсөх, шинээр хэдэн “старт-ап” компани байгуулагдах, дата төвд ажиллах гадаад ажилчдын квотын асуудал, банк, санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа иргэдийн мэдээллийг гуравдагч банк, санхүүгийн байгууллагатай солилцох зохицуулалт, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг хуулийн төсөл нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуультай нийцэж байгаа эсэх, хүний эмзэг мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, солилцох, дамжуулах, дахин дамжуулах болон төлбөртэй ашиглуулах зохицуулалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтад нийцэж байгаа эсэх,

гадаадын дата төвд Монгол Улсын хууль тогтоомж үйлчлэх эсэх, дата төвийн халдашгүй байдлын эрх зүйн үндэслэл, дотоодын аж ахуйн нэгжийн эрх ашиг, мэдээллийн аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалтын талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат хуулийн төслийн 20.1 дэх хэсгийг Статистикийн тухай хуультай уялдуулах, холбогдох хуулиудын давхардал, зөрчлөөс сэргийлэх, өгөгдлийн төвд суурилсан технологийн хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх тодорхой, тогтвортой эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Монгол Улс хиймэл оюун, өгөгдлийн эдийн засаг, дата төвийн талаар баримталж байгаа бодлого, хиймэл оюуны хөдөлмөрийн зах зээл, ажлын байранд үзүүлэх нөлөө болон болзошгүй эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Монгол Улсын хүйтэн сэрүүн уур амьсгал, сэргээгдэх эрчим хүчний нөөц, хөрөнгө оруулалт татах боломжид тулгуурлан дата төвийг хөгжүүлэх бодлогыг дэмжиж байгаагаа илэрхийлээд, олон улсын корпорацууд, тэр дундаа үндэстэн дамнасан компаниуд Монгол Улсад дата төв байгуулах сонирхол илэрхийлсэн эсэх, гадаадын дата төвд олгох халдашгүй байдлын эрх нь зөвхөн өгөгдөлд хамаарах эсэх, эсхүл дата төвийн барилга, байгууламж, орчинд мөн үйлчлэх эсэх, дата төвөөс ялгарах дулааныг ашиглан хот, суурин газрын дулаан хангамжийг нэмэгдүүлэх боломж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн хууль батлагдсанаар иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд гарах бодит өөрчлөлт, төсөлд тусгагдсан төрийн их өгөгдлийн дэд бүтэц, өгөгдөл солилцоонд үйлчлэх журам батлах зохицуулалт нь оновчтой эсэх, жижиг, дунд бизнес эрхлэгчид өгөгдөлд мэдээлэл нийлүүлэхэд нэмэлт зардал, хүндрэл үүсгэх эсэх, бизнесийн нууц болон мэдээллийн нууцлал, аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, дата төвөөр арилжааны болон үүлэн тооцооллын үйлчилгээ үзүүлэх, өгөгдлийг бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хөгжүүлж ажлын байр, бизнесийн өсөлтийг нэмэгдүүлэх, мөн өгөгдлийг ангилах, төлбөртэй ашиглуулах, хувийн мэдээллийн нууцлалыг ханган нийтийн ашиг сонирхолд ашиглах болон хараат бус зуучлагч, баталгаажуулагчийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх зохицуулалтын талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нийтийн мэдээллийн өмчлөлийн талаарх зохицуулалтыг тодорхой болгох, Нийтийн өмчийн тухай хуулийн төсөлтэй уялдуулах, мөн мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, үндэсний өгөгдлийн дэд бүтцийн бэлэн байдлыг үнэлж, цаашдын хөгжлийн төлөвлөлтийг тодорхойлох, мэдээллийн болон серверийн аюулгүй байдлыг баталгаажуулах, болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа өгөгдөл, хиймэл оюуныг ашиглан төрийн бодлого, хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх, дата төвөөр дамжуулан хөрөнгө оруулалт татаж, эдийн засгийг төрөлжүүлэхийн зэрэгцээ эмзэг мэдээллийн нууцлал, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах тогтвортой эрх зүйн орчин бүрдүүлж, холбогдох хууль тогтоомжийн уялдааг хангах шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал үндэсний өгөгдлийн дэд бүтцийг хөгжүүлэх болон гадаадын дата төв байгуулах асуудал нь өөр өөр зорилго, зохицуулалттай тул эрх зүйн хувьд ялгаж авч үзэх, өгөгдлийн эзэн, эзэмшигч, хариуцагч, хэрэглэгч, боловсруулагч, нийлүүлэгч, зуучлагчийн эрх, үүргийг тодорхой болгож, тэдгээрийн эрх, үүрэг давхцах болон хоорондоо маргаан үүсэх тохиолдолд аль зохицуулалтыг баримтлахыг хуульд нарийвчлан тусгах, өгөгдөл нь Иргэний хууль болон Төрийн

болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд өмчид хэрхэн хамаарахыг тодорхойлж, холбогдох хуулиудын уялдааг хангах замаар өмчлөл, эзэмшлийн маргаан болон арбитрын маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх, гадаадын дата төв байгуулах замаар хөрөнгө оруулалт татах боломжийг ашиглахын зэрэгцээ дата төвийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, төрийн байгууллагын хяналт шалгалт, хууль сахиулах ажиллагаа болон шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, дата төвийн халдашгүй байдлын хүрээ, хязгаарлалтыг олон улсын жишигт нийцүүлэн нарийвчлах талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг өгөгдөл, дата төвийн үйл ажиллагаа, кибер аюулгүй байдал, мэдээлэл хадгалалтын стандарт, оролцогч талуудын эрх, үүрэг, харилцааг олон улсын жишигт нийцүүлэн нарийвчлан зохицуулах, эрх зүйн тодорхой орчин бүрдүүлснээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, дата төвийн дэд бүтцийг хөгжүүлэх, эрчим хүчний өндөр хэрэглээг сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй уялдуулах, дотоодын аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх боломж бүрдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл өгөгдөл үүсгэх, хадгалах, боловсруулах, ашиглахтай холбоотой аюулгүй байдлыг хангах, хиймэл оюуны хэрэглээтэй холбоотой олон улсын түвшинд анхааруулж буй эрсдэл, болгоомжлох асуудлуудыг харгалзан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй талаар байр сууриа илэрхийлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт "... Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна ..." гэж заасны дагуу санал хураалт явуулахад Өгөгдлийн тухай хуулийн төслийг 87.5 хувиар, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 83.3 хувиар, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 87.5 хувиар, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 87.5 хувиар, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 87.5 хувиар, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 87.5 хувиар тус тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өгөгдлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА **Б.ЗАЯАБАЛ**